



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх Ухааны Сургууль

Хөтөлбөрийн нэр: Нийгмийн ажил

Индекс: D092301

Шинжээчийн баг:

Ахлагч: Н.Нямдорж
Гишүүд: Н.Оюут-Эрдэнэ
Д.Мөнхчулуун

Улаанбаатар хот
2021 оны 5- сарын 17-18

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БСШУ	Боловсрол соёл шинжлэх ухаан
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
БХЦСТ	Багшийн хөгжил, цахим сургалтын төв
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
МУИС	Монгол улсын их сургууль
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
НАБСХ	Нийгмийн ажлын багш, сургагчдын холбоо
НСХ	Нийгмийн судалгааны хүрээлэн
ОУНАХ	Олон улсын нийгмийн ажилтны холбоо
ОУБ	Олон улсын байгууллага
ОУУБИС	Олон улсын Улаанбаатарын их сургууль
ӨҮТ	Өөрийн үнэлгээний тайлан
СНАТ	Социологи, Нийгмийн ажлын тэнхим
ШУС	Шинжлэх ухааны сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр	Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль	
Хөтөлбөрийн нэр, индекс	Нийгмийн ажил Индекс: D092301	
Шинжээчид	<p>Ахлагч: Н.Нямдорж - Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн Нийгмийн ажил хөтөлбөр хариуцсан дэд профессор, доктор (Ph.D)</p> <p>Гишүүд: Н.Оюут-Эрдэнэ - Монгол улсын боловсролын их сургуулийн Боловсрол судлалын сургуулийн Нийгмийн ажил, арга зүйн тэнхимийн ахлах багш Д.Мөнхчулуун - Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, доктор (Ph.D)</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Оюунцэцэг	
Төлөвлөгөө	Өдөр	Хийгдсэн ажлууд
	2021.05.07	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2021.05.11	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2021.05.15	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2021.05.17,18	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2021.05.25	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
	2021.05.27	Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 001 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Социологи, Нийгмийн ажлын тэнхим нь 1991 онд Социологийн тэнхим нэртэйгээр байгуулагдаж, “Социологи” хөтөлбөрөөр сургалт явуулж байгаад 2000 онд “Нийгмийн ажил” хөтөлбөрийг нээж элсэлт авсан, тэнхимийн нэрийг 2006 онд албан ёсоор “Социологи, Нийгмийн ажлын тэнхим” болгож өргөтгөсөн. Тус тэнхимийн “Нийгмийн ажил” хөтөлбөр Монгол улсын хэмжээнд гурав дахь хөтөлбөр болно. Анх нээгдсэнээс хойш тасралтгүй хорин жил элсэлт авч төгсөлт хийж нийтдээ 467 мэргэжилтнийг төгсгөжээ.

Тус хөтөлбөр нь Монгол улсын Дээд боловсролын тухай хууль, БСШУ-ны сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаал, Стандартчилал хэмжил зүйн газрын баталсан Нийгмийн ажлын дээд боловсролын MNS5323-94:2009 стандарт, Олон улсын нийгмийн ажлын сургуулиудын холбооноос баталсан Дэлхийн нийгмийн ажлын боловсрол, сургалтын стандартын шаардлага, МУИС-ийн бодлого, дотоод дүрэм журамд нийцүүлэн боловсруулагдсан байна.

2014 онд МУИС-д хэрэгжсэн бүтцийн өөрчлөлт, хөтөлбөрийн шинэчлэлээр “Нийгмийн ажил” хөтөлбөрийн агуулгыг холбогдох шаардлагын дагуу дэлхийн нийгмийн ажлын тэргүүлэх гурван их сургуулийн хөтөлбөртэй харьцуулан боловсруулан батлуулж, өнөөг хүртэл тогтвортой хэрэгжүүлж, сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. Өдгөө тус хөтөлбөр нь 16 багш, нэг туслах ажилтантай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2021 эхний улирлын байдлаар нийтдээ 108 оюутан суралцаж байна.

БСШУЯ-ны боловсруулсан “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал”-д “Дээд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, судалгааны чиглэлийг нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно” гэсэн стратегийн зорилтыг тодорхойлсон байдаг. Энэ зорилттой холбоотой МУИС-д хэрэгжиж буй нийгмийн ажлын хөтөлбөрийн дэд хороо, багш нарын баг нь дотоод хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, өөрчлөлт, түүний төлөв байдлыг шинжлэн судлаж, нийгмийн ажлын мэргэжлийн эрэлт, хэрэгцээ, чиг хандлагыг тодорхойлж, хөтөлбөрийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо:

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгцээ, хөтөлбөрийн зорилго, төлөвлөлтийн баримт бичгүүдэд хамаарах бүхий л нотлох баримтуудыг бүрэн бүрдүүлсэн.
- Нийгэм эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ (PEST анализ)
- Гадаад, дотоодын их сургуулиудын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын жишиг, ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулан боловсруулсан.
- ✓ Нийгмийн ажил хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн нэршил, багц гадаад орнуудын их дээд сургуулиудын хөтөлбөрийн хичээлүүдийн агуулгатай нийцсэн байна.

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрийн сургалтанд оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээг хийж, оролцогч талуудын оролцоог хангах
- ✓ Нийгмийн ажил, нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн чиг хандлага болон эрх зүйн шинэчлэлийг судлан, хөтөлбөртэй уялдуулж төгсөгчийн ажлын байрны эрэлт хэрэгцээг тодорхойлоход анхаарах хэрэгтэй байна.

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийхдээ ямар шалгуурыг баримтлах, давуу болон сул талаа тодорхойлж, бүрэн шинэчлэл хийгээд 7 жил өнгөрсөн байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- CDIO Syllabus 2.0-ийн 1-р түвшний сургалтын үр дүнгүүд
- Хөтөлбөрийн сургалтын зорилгууд,

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Хөтөлбөрийн онцлогт тохируулан МУИС-ийн нийт нэгдүгээр түвшний ангид хичээл ордог.
- ✓ Хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь CDIO сургалтын аргын 1-р түвшний үр дүнтэй уялдуулж матриц хийсэн

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар ажил олгогч, төгсөгч нарт танилцуулдаг энэ талаар тэдний саналыг сонсдог байхад анхаарах.
- ✓ Хөтөлбөрийн оролцогч талуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж албажуулах

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилгод судалгаа хийх, ажил олгогч, төгсөгч нараас санал авах, хэлэлцүүлэх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдтэй холбоотой нотлох баримтуудыг бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Сургалтын төлөвлөгөөнд шинэчлэлт оруулахдаа Нийгмийн ажлын хөтөлбөрийн мэргэжлийн багш нарын баг, хөтөлбөрийн дэд хороо, МУИС-ийн Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын албаар тус тус хэлэлцүүлдэг байна.
- ✓ Сургалтын хөтөлбөрт оруулсан өөрчлөлтүүдийг цэгцтэй илэрхийлж, багц цагийн өөрчлөлт, сургалтын арга зүйн өөрчлөлт, залгамж холбоо, хөтөлбөрийн дотоод агуулгын өөрчлөлт, үнэлгээний олон талт аргуудын талаар дэлгэрэнгүй тайлбарлажээ.
- ✓ МУИС либерал арт хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий эрдмийн хичээлүүдэд Нийгмийн ажил (SOWO100), Нийгмийн судалгааны аргууд (SOWO101) хичээлүүдийг оруулдаг байна.
- ✓ Хөтөлбөрийн төлөвлөлтөд SWOT, TOWS шинжилгээ хийсэн.

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрт дотоод болон гадаад орчны хүчин зүйлийн чанарын баталгаажуулалт хэрхэн хийгдэж байгаа нь тодорхойгүй байна.
- ✓ Хөтөлбөрийн төгсөгчийн цогц чадамжийг үнэлэх аргачлал, үнэлгээ хийгдээгүй байна.

Зөвлөмж:

- ✓ Мэргэжлийн холбоод, ажил олгогч болон бусад оролцогч талуудын санал, зөвлөгөөг хөтөлбөр шинэчлэхдээ тусгах
- ✓ 2020 оны Дэлхийн нийгмийн ажлын боловсрол, сургалтын стандартын шаардлагатай нийцүүлж хөтөлбөрийг хөгжүүлэх хэрэгцээ байна.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Баримт нотолгоо:

- Хичээл хоорондын залгамж холбоог зураглалын модоор гаргасан байна.
- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матрицийг хийсэн.

- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матрицийг хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ “Нийгмийн ажилтан” хөтөлбөрөөр суралцагсдын цогц чадамж ба сургалтын уялдааг мөрдөн ажиллаж байна.
- ✓ Нийгмийн ажлын дээд боловсролын стандарт болон хөтөлбөрийн онцлогтой уялдуулан дадлагын багц цаг нь бусад ижил хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулиудаас илүү байна.
- ✓ Монгол орны түүх, соёлтой холбоотойгоор “Нийгмийн ажил ба соёл” хичээлийг оруулахаар төлөвлөсөн нь онцлог байна.

Анхаарах асуудал:

- ✓ Нийгмийн ажил хөтөлбөрийн өөрчлөлт нь 2015 оны 8 сарын 25-ний өдөр батлагдсан болохыг цаашид анхаарах
- ✓ Дадлагын гэрээ байгуулах, санамж бичиг, удирдамж, журам, дадлагын тайланг гаргах.
- ✓ Нийгмийн үйлчилгээний төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж албажуулах ба бусад орнуудын их сургууль, коллежтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах
- ✓ Хичээлийн агуулгын давхардал байгаа эсэх, ямар түвшинд байгаа талаар тайлбар дүгнэлт хийгдээгүй.
- ✓ Хөтөлбөрийн мэргэжлийн судлах хичээлүүдийн хувьд суралцагчийн зүгээс багшаа сонгон суралцах боломжийг судлах

Зөвлөмж:

- ✓ Батлагдсан сургалтын төлөвлөгөөний оюутанд санал болгох хувилбараар Оюутны цагийн ачаалалд дүн шинжилгээ хийж, тооцох шаардлагатай.
- ✓ Дадлага хийсэн оюутнууд болон байгууллагын тоо, дадлага удирдагч, түүнд ногдох цагт дүн шинжилгээ хийж ажиллах
- ✓ Хичээлийн агуулгын давхардал байгаа эсэхийг нэгж хичээлийн хөтөлбөр тус бүрийн хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэх үедээ нарийвчлан авч үзэх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд багш болон суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд олон төрлийн арга зүй ашигладаг ба арга зүйн журмыг боловсруулсан байна. (МУИС 2010, 2015, 2019)
- 2018 оноос тус хөтөлбөрийн багш нар өөрсдийн заадаг хичээлүүдийг цахим хэлбэрт оруулах ажил эрчимтэй хийгдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Багш суралцагчдын судалгааны түвшинд тухайн хөтөлбөрийн агуулга, арга зүй танигдан, мэдээлэгдэж байна.
- ✓ Сургалтын СиСи системийг нэвтрүүлсэн байна

Анхаарах асуудал:

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд хэрхэн зөвлөн тусалдаг, суралцах үйл ажиллагааг хэрхэн дэмжих талаар анхаарах, энэ талаар сургалтын баримт бичгүүдэд оруулах шаардлагатай байна.
- ✓ Сургалтын арга зүй нь багшийн сургах арга, оюутны сурах үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн үйл ажиллагаа явуулах.

Зөвлөмж:

- ✓ CDIO загвараар хөтөлбөрийн онцлогтой (нийгэм, хүмүүнлэгийн) нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцох хэрэгтэй.
- ✓ Хичээл тус бүрийн танилцуулга нь суралцагчийн мэдлэг, чадварын ерөнхий хүрээгээр тодорхойлогдож байгаа эсэхийг нотлох
- ✓ Оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч байгаа боловч хөтөлбөр болон нэгж хичээлийн хөтөлбөрт хэрхэн тусгаж байгаа нь тодорхой бус байгааг анхаарч ажиллах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

- МУИС-ийн сургалтын журмын дагуу үнэлгээний арга зүй
- Нийгмийн ажил хөтөлбөрөөр суралцагчдын шалгалт болон бие даалтын хэлбэрт хийсэн дүн шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Давуу тал:

- ✓ Хичээл тус бүрийн үнэлгээний Рубрикийг боловсруулж, хичээлийн хөтөлбөрийн үнэлгээг илүү тодорхой болгож, танилцуулдаг.
- ✓ Сиси системд оюутны дүнг баталгаажуулан оруулдаг.

Анхаарах асуудал:

- ✓ Сурлагын онцгой амжилт чанарыг үнэлэн оюутнуудыг дэмжих дэмжлэгийн тогтолцоог хөгжүүлэх
- ✓ Оюутныг тасралтгүй хөгжүүлэх идэвхтэй бүтээлч аргыг хэрэглэн ур чадварыг хөгжүүлэхэд багш нар анхаарах.
- ✓ Суралцагчийг тасралтгүй хөгжихөд тусалж байгаа эсэхэд үнэлгээ шинжилгээ хийдэг, сайжруулах алхамууд тодорхой төлөвлөгөөтэй байхад анхаарах

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийн хичээлийн үнэлгээний сан бүрдүүлэн ажиллах, үнэлгээний сангийн агуулга хэлбэрийг зохих түвшинд үнэлдэг байх
- ✓ Хичээл нэг бүрийн үнэлгээнд тогтмол дүн шинжилгээ хийх

- ✓ Суралцагчийн тасралтгүй хөгжлийн асуудлаар салбар сургуулийн оюутны холбоотой хамтран ажиллах

Шаардлага:

Хөтөлбөрөөр суралцагчдын тасралтгүй хөгжлийн асуудалд анхаарсан дэмжлэгийн тогтолцоог хөгжүүлэх, амжилттай суралцсан суралцагч бүрт урамшууллын талаархи мэдээллийг өгөх, хичээл тус бүрийн үнэлгээнд тогтмол дүн шинжилгээ хийх, суралцагчийн хөгжлийн асуудалд нийгмийн хамгааллын мэргэжлийн байгууллага, холбоодын оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим нь 3 хичээлийн танхимтай, түүнд 6 самбар, 3 проектор, 1 телевизор, багш нарын 4 өрөө / нийт 350 мк2 талбайтай/ 63 ширээ, 143 сандал, 16 компьютер, 8 принтер, 2 хүчин чадалтай канон хувилагч машин байршснаар сургалтын үйл ажиллагаа явагдаж байна.
- Нийгмийн судалгааны дата лаборатори 2019-02-7нд нээлтээ хийсэн нь суралцагчдын судалгаа шинжилгээ хийх ур чадварыг нэмэгдүүлэх, бие даан суралцахад чиглэсэн судалгаа шинжилгээ мэдээлэл боловсруулах, эмпирик холбогдох мэдээллийн санг бүрдүүлж ашиглах зориулалттай бөгөөд уг лабораторид тоон мэдээлэл боловсруулах IBM SPSS statistics 24.0, STATA IC 15, CPro 7.3, мөн чанарын мэдээлэл боловсруулах QUALITATIVE RESEARCH PROGRAM зэрэг програм хангамж суулгасан 15 суурин болон зөөврийн компьютеруудтай байна.
- Сургалт семинарын олон талаар ашиглах боломжтой LEGO ширээ, сандал, уулзалт хийх, ганцаарчилсан ярилцлага хийх өрөө тасалгаа, бүлгийн ярилцлага, хэлэлцүүлэг хийх ширээ, сандал, эрдэмтэн судлаачид, ахисан болон бакалаврын түвшний оюутнууд багаар ажиллах боломж бүхий компьютерийн ширээ, сандал, ном, сонин, судалгааны материал зэрэг хэвлэмэл мэдээллийг хадгалах тавиур, шүүгээ гэх мэт тохилог орчинд нийгмийн ухааны багш, суралцагчид бие даан суралцах боломж бүрдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Нийгмийн судалгааны хүрээлэнгийн дата лаборатори нь суралцагчдын судалгаа шинжилгээ хийх ур чадварыг нэмэгдүүлэх, бие даан суралцахад сайн нөлөө үзүүлэх, суралцагчид мэргэжлийн чиглэлээр хөгжих бүрэн боломжийг нээсэн хэрэгцээт орчин болсон байна.

Анхаарах асуудал:

- ✓ Суралцагчдыг дата лабораторийг түшиглэн технологийн дэвшилтэт шинэ аргуудад жигд суралцуулах, онлайн сургалтын платформыг хөгжүүлэх,
- ✓ Багш нарын өрөөг ажлын байрны орчны стандартын жишигт нийцүүлэх, тав тухтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх

Зөвлөмж:

- ✓ Суралцагчид цахим орчинд суралцах, хэрэгтэй мэдээллээ авахад тэдний сэтгэл ханамжид нийцсэн технологийн нөхцлийг бүрдүүлэх, интернетийн хурд, хүртээмжийг нэмэгдүүлэх,

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Бүрэлдэхүүн сургууль, салбар нэгжүүд нь багш суралцагчдын суралцах, судалгаа шинжилгээ хийх орчин үеийн сургалтын шинэ техник технологийн дэвшлийг хангахуйц ажлуудыг жил бүр тогтмол хийж ирсэн байна. Сургалт явуулахад хангалттай материаллаг нөөц хэрэгсэл, онлайн орчинд ажиллах орчныг бүрдүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Давуу тал:**

- ✓ Сургалт явуулахад шаардлагатай хичээл практикийн материаллаг нөөц хангалттай, дижитал видео, аудио эх үүсвэр, сургалт судалгааны лицензтэй программаар хангагдсан байна.
- ✓ Багш нарын онлайн нөхцөлд ажиллах орчны нөхцлийг бүрдүүлж, сургалтад хэрэглэгдэх техник, дагалдах хэрэгслээр хангасан бол суралцагчдад үүрэн телефоны байгууллагуудтай хамтран, интернетээр үнэгүй, хөнгөлөлттэй үйлчлүүлэх боломжийг олгосон үйлчилгээг санал болгож, нэвтрүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- ✓ Багш нар онлайн хичээлийн вэб хуудаст өөрсдийн бэлтгэж буй цахим хичээлийг байршуулах ажлыг идэвхжүүлж, суралцагчдад болон олон нийтэд хүргэх боломжийг нээлттэй байлгах,
- ✓ Нийгмийн ажлын олон улсын түвшинд хэрэглэгдэж, шинээр нэвтэрч буй онол, арга зүйн ном, гарын авлагаар тэнхмийн номын сангийн фондыг баяжуулах

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийн онцлогт тохирсон, зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцийн хэрэгцээг тодорхойлсон судалгааг жил бүр суралцагчдаас авч байх, судалгаанд суурилсан баяжилтыг тогтмол хийх.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Баримт нотолгоо:

- МУИС нь олон улсын дэвшилтэт технологид суурилсан номын сангийн автоматжуулсан КОНА цогц програм хангамж өгөгдлийг ашиглах, дэлхий нэр хүндтэй их сургуулиудын онлайн сэтгүүл, e- номын сан ашиглах боломжийг бүрэн бүрдүүлсэн байна.
- Номын сангийн сан хөмрөгт социологи, нийгмийн ажлын чиглэлээр нийт 2497 төрлийн 7999 сурах бичиг, ном, гарын авлага хадгалагдан ашиглагдаж байгаагийн 70 орчим хувь нь эх хэл дээр, үлдсэн нь англи, орос, герман болон бусад хэл дээр байна. Түүнээс гадна СНАТ-ийн номын санд зарим нэг тулгуур ном сурах бичиг болон бакалаврын дипломын ажлыг коджуулан оюутны хэрэгцээнд ашиглаж байна.
- Үүнд одоогийн байдлаар 221 ширхэг ном сурах бичиг, гарын авлага, нийгмийн ажлын сэтгүүл 57 ширхэг, 2010-2020 онд бичиж хамгаалсан дипломын ажил 272 ширхэг тус тус байна. СНАТ-аас нийгмийн ажлын сэтгүүлийг 12 дахь жилдээ олон улсын сэтгүүлийн дугаартай эрхлэн гаргаж, дотоод гадаадын багш, эрдэмтэн судлаачдын мэргэжлийн онол-арга зүй, судалгаа шинжилгээ, эрдэм шинжилгээний өгүүллүүдийг хэвлүүлэн гаргаснаас 30%-ийг цахим хэлбэрт шилжүүлэн оюутнууд ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Номын сан нийт уншигчид, суралцагчдад чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх гадаад, дотоод орчны шинэ таатай нөхцлийг бүрдүүлснээс гадна ном сэтгүүл, хэвлэлийн бүтээгдэхүүний бүрдүүлэлтийг хийж, каталогжуулах, баяжилт хийх, шинээр ном худалдан авах зэрэг дотоод ажлын чанарт дэвшил гаргаснаас гадна үйлчлүүлэгчдэд хүргэх сургалт мэдээлэл, сурталчилгаа, ажилтнуудын ажлын туршлага, мэдлэг харилцаа хандлагын эерэг байдлуудыг бүрдүүлж чадсан байна.
- ✓ Тэнхимын номын фондыг үүсгэж, тэнхимдээ байршуулсан нь үйлчилгээг ойртуулж, цаг хэмнэж, суралцагчдын хэрэгцээг хангаж байна.

Анхаарах асуудал:

- ✓ Мэргэжлийн чиглэлийн ном гарын авлагын зайлшгүй хэрэгцээг судлан жагсаалт гаргаж, захиалах, худалдан авах зэргээр номын сангийн “Нийгмийн ажил” хэсгийн баяжилтыг бүрдүүлэх, суралцагчдын уншиж, судлах хэрэгцээг бүрэн хангах
- ✓ E контентийн хэрэглээг цогц болгон хөгжүүлэх, суралцагчид цахим орчноос хэрэгтэй мэдээллээ бүрэн авах боломжийг бүрдүүлэх, нэмж уншиж судлах материалын хэрэгцээг судлан, түүнд суурилсан баяжилт хийх

Зөвлөмж:

- ✓ Нийгмийн ажлын хөтөлбөрийн багш нар мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ, хүртээмжийн талаар болон цахим хичээл, түүний чанарын талаар суралцагчдаас санал асуулга авч, үр дүнд суурилсан төлөвлөгөө гарган ажиллах.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

- МУИС-ийн стратеги төлөвлөгөө 2016-2024
- МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны журам, Сургалтын журам
- Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж
- Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага
- МУИС-ийн Хөтөлбөрийн хороо, Бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн хороо, тэнхимийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл
- Нийгмийн ажил бакалаврын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан, хавсралтууд тухайлбал СНАТ-ийн жилийн ажлын тайлангууд

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Давуу тал:

- Сүүлийн таван жилд МУИС-ийн хэмжээнд хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, чанарын баталгаажуулалтын чиглэлээр журам заавар шинэчлэгдэн гарч, тогтолцоо боловсронгуй болсон.
- Сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, чанартай явуулахад МУИС-ийн ХЧБХ, бүрэлдэхүүний сургууль болон тэнхимийн удирдлага анхаарч ажиллан СиСи системээр баталгаажуулдаг.
- СНАТ-ийн Хөтөлбөрийн хороо байнгын ажиллагаатай.
- Төсөлт үйл ажиллагааны үр дүнг хөтөлбөрийг сайжруулахад тусгаж хичээлийн хөтөлбөр агуулгыг сайжруулсан. Тухайлбал жендэрт суурилсан хүчирхийлэл хичээл.

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрийн шинэчлэлийг хичээлүүдийн хүрээнд тогтмол хийж байгаа ч нийгмийн ажил хөтөлбөрийн хүрээнд цогцоор хийж баталгаажуулах ажил цаг үеийн хэрэгцээг тусган хийгдэх шаардлагатай.
- ✓ Мэргэжлийн байгууллага, ажил олгогчидтой хөтөлбөрийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд хамтрах
- ✓ Хичээлийн хөтөлбөрийг боловсруулах удирдамжид багшийн заах арга зүйг тусгах, хичээлээр ашиглах материалыг заавал судлах болон нэмэлтээр судлах гэж ялгаж салгаж зааж өгөх талаар тусгах

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлэх
- ✓ Мэргэжлийн байгууллага, ажил олгогчидтой хөтөлбөрийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд хамтрах, хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажиллах

- ✓ Шат шатны Хөтөлбөрийн хороодоос хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж гаргах, үүний мөрөөр тэнхим болон багшийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг үнэлэх дүгнэх
- ✓ Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамжийг боловсронгуй болгох

Шаардлага: /Бүрэн хангасан бол бичихгүй/

- Хөтөлбөрийн шинэчлэл өөрчлөлтийг хэсэгчилсэн байдлаар бус цогц байдлаар батлах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

- Сургалтын хөтөлбөр боловсруулах, судалгаа эрдэм шинжилгээ, нийгэм олон нийтэд зориулсан мэргэжлийн үйл ажиллагаа зэрэг чиглэлүүдээр төрийн, төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- Японы Шукүтоку их сургуулийн Олон улсын нийгмийн ажлын Азийн судалгааны институт зэрэг олон улсын их дээд сургууль, судалгааны байгууллагуудтай хамтран ажилласан тайлан мэдээ
- Ажил олгогчид, төгсөгчид, суралцагчидтай хийсэн цахим уулзалт
- СНАТ-ийн багш нарын оролцсон зөвлөх үйлчилгээний мэдээ, тайлан
- Багш нарын сургалт, төсөл хөтөлбөрт хамрагдсан, хэрэгжүүлсэн тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Байнга хамтарч ажилладаг дадлагын түшиц байгууллагуудтай бөгөөд төгсөгчид нь мэргэжлийн дадлага удирдагч багшаар ажилладаг. Дадлагын удирдагч нарт урамшуулал олгодог.
- Суралцагчид болон багш нарыг хөгжүүлэх, чадавхижуулахад чиглэсэн олон талын хамтын ажиллагаа бүрдүүлж ажилласан давуу тал харагдаж байна.
- Олон улсын болон үндэсний хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллахын зэрэгцээ нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлэх хүрээнд байгууллага, олон нийтэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, хамтарсан судалгаа хийх, төсөл хэрэгжүүлж туршлага, үр дүнг хичээл сургалтад ашиглаж, хөгжүүлж буй байдал ажиглагдсан.
- МУИС-аас багшийг дэмжих болон оюутны олон тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- ✓ Олон улсын болон үндэсний нийгмийн ажлын мэргэжлийн нийгэмлэг холбоодтой хамтын ажиллагаа тогтоох, өргөжүүлэх

Зөвлөмж:

- ✓ Олон улсын /Ази номхон далайн орнуудын/ нийгмийн ажлын сургуулиудын холбоонд СНАТ институцийн хувьд гишүүнчлэлтэй болох, олон улсын нийгмийн ажлын боловсролын хөтөлбөр, төсөлд хамтын ажиллагааг өргөжүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Баримт нотолгоо:

- 2014-2020 оны Шинжлэх ухааны сургуулийн санхүүгийн ерөнхий үзүүлэлт, төлөв зэрэг, тогтвортой байна.
- Хөтөлбөрийн багшийн хөгжлийн дэмжих үйл ажиллагаанд 2015-2020 онд 118,0 сая төгрөгийг олгосон байна.
- Хөтөлбөрийн багш нарын оролцсон төсөл, хөтөлбөр, захилгат сургалт, судалгааны ажлын гүйцэтгэлд 364,0 сая төгрөгийн ажил хийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Давуу тал:**

- ✓ Хөтөлбөрийн багш нар гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, захиалгат сургалт, судалгааны ажлыг гүйцэтгэж, оролцдог.
- ✓ Сургуулийн зүгээс багш нарт зориулан нэг сая төгрөгийн тэтгэлэг олгодог бөгөөд энэ нь тэдний хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг байна.

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрийн санхүүгийн үйл ажиллагаанд анализ хийх хэрэгтэй байна.
- ✓ Хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлтөд чиглэсэн тусгай төсөв байхгүй байна.
- ✓ Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа төслийн санхүүжилт, түүний эргэн тайлагнах үйл явцын мэдээлэл хомс байна.
- ✓ Багшийн хөгжил, сургалт семинар, мэргэжил дээшлүүлэх, багш нарын эрдэмжилт зэрэгт зарцуулсан зардлын тухай мэдээллийг бусад үзүүлэлтийн адил тодорхой гаргаж, дүн шинжилгээ хийх

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийг сайжруулахад чиглэсэн төлөвлөгөө төсөл, төсөв боловсруулж ажиллах
- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш, оюутны хөгжилд үзүүлж буй олон талын эх үүсвэрийн мөнгөн бус дэмжлэгийг тооцож, дүн шинжилгээ хийх
- ✓ Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуурт санхүүгийн асуудлыг оруулах
- ✓ Гадаадын улс орны сургуулиудын тэргүүн туршлагыг хөтөлбөрийн санхүүжилт бүрдүүлэхэд дутмаг ашигласан, төгсөгчдийн оролцоо, бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- ✓ Хөтөлбөрөөр суралцагсдад дэмжлэг үзүүлэх санхүүгийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Баримт нотолгоо:

- МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
- Соц-НА төгсөгчдийн групп гэх мэт нийгмийн сүлжээг ашиглах бүтэц зохион байгуулалт
- МУИС-ийн вэбсайт, сургалтын удирдлага мэдээллийн систем

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Давуу тал:**

- МУИС-ийн брэнд нэр хүнд хөтөлбөрт давуу тал болж байна.
- Нийгмийн ажил хөтөлбөрт элсэгчид, нийгмийн ажлын ерөнхий суурь хичээл, чөлөөт сонголтоор хичээл судлах суралцагчдын тоо өсөлттэй байна.
- Нийгмийн ажлын хөтөлбөрт элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо өндөр (655, 602,6).
- МУИС-ийн журам дүрмийн дагуу хөтөлбөрийн маркетинг хичээлийн жилд 2-оос доошгүй удаа хийдэг. Хээрийн дадлагын тайлан хамгаалалтыг сургуулийн хүрээнд нээлттэй зохион байгуулдаг нь нийгмийн ажлын хөтөлбөрийн сурталчилгаа болдог.
- МУИС-ийн оюутнууд нийгэм, олон нийтийн сайн дурын хөдөлгөөн, үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог нь хөтөлбөрийн маркетингийн чиглэлээр хувь нэмрээ оруулдаг байна.

Анхаарах асуудал:

- ✓ МУИС-ийн дотоодод хөтөлбөрийн маркетингийн үйл ажиллагаа хангалттай хэдий ч сургуулийн гадаадад буюу олон нийтэд хөтөлбөрийн болон нийгмийн ажлын мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх.
- ✓ Хөтөлбөрийн маркетингийн бичиг баримт боловсруулахдаа нийгмийн ажил хөтөлбөрийн зорилго зорилтыг тусгах

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Баримт нотолгоо:

- МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
- МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам
- МУИС-ийн вэбсайт, элсэлтийн цахим хуудас, бүртгэлийн нэгдсэн систем, ахисан түвшний сургуулийн цахим хуудас
- МУИС-ийн сургалтын удирдлага мэдээллийн СиСи систем
- Соц-НА фейсбук
- “Нийгмийн ажил” сэтгүүл
- МУИС-ийн багш нарын youtube дээрх онлайн мэргэжлийн танилцуулга, яриа
-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Давуу тал:**

- Нийгмийн ажил хөтөлбөрийн танилцуулга МУИС-ийн бакалаврын хөтөлбөрүүдийн танилцуулгад хэвлэгдэн суралцагчийн гарын авлага тараагддаг.
- МУИС брэнд нэрээр хөтөлбөр олон нийтэд танигдсан. Хөтөлбөр сурталчлах өдөрлөг жилд 2 удаа зохион байгуулагддаг.

- Элсэх, шилжих, төгсөх, мэргэжлийн хөтөлбөр сонгох зэрэг сургалтын үйл ажиллагаа СиСи системээр явагддаг, тогтмол ажиллагаатай.
- Либерал арт дээр суурилсан хөтөлбөрийн давуу тал нь ерөнхий суурь хичээлийг нээлттэй зохион байгуулж олон мэргэжлийн оюутан судалдаг.
- СНАТ-ээс олон улсын индекстэй “Нийгмийн ажил” мэргэжлийн сэтгүүлийг эрхлэн гаргадаг.
- Иргэдэд сонирхсон чиглэлээр хөтөлбөрийг танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн талаар элсэлтийн хүрээнд хязгаарлагдмал мэдээлэл түгээдэг. Хөтөлбөрийн үндсэн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтыг сурталчилгаа мэдээлэлд тусгах
- ✓ СНАТ нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийгмийн ажлын хөтөлбөрийг олон нийтэд таниулах, нийгмийн ажлын мэргэжлийг сурталчлах таниулахад анхаарах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Баримт нотолгоо:

- МУИС нь бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журмыг боловсруулан баталж, бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлтийг холбогдох дүрэм журмаар зохицуулж зохион байгуулж байна.
- Хөтөлбөр сонголтын үйл ажиллагаа нь тусгай журмаар зохицуулагддаг бөгөөд хөтөлбөр сонгох, баталгаажуулах, сонгон судлах гэсэн үндсэн гурван үе шаттайгаар явагддаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Нийгмийн ажил хөтөлбөрийн ерөнхий суурийн хичээлүүдийг судалсны дараа сонгох боломжийг олгодог ба хөтөлбөр таниулах үйл ажиллагааг цогц хэлбэрээр зохион байгуулж, сурталчилснаар сүүлийн жилүүдэд тус хөтөлбөрийг сонгох оюутны тоо нэмэгдэж байна.

Анхаарах асуудал:

- ✓ Нийгмийн ажил, мэргэжлийн онцлогийг цогц байдлаар харуулсан, орчин үеийн шинэлэг технологид суурилсан цахим контент бэлтгэж, түүгээр дамжуулан олон нийтэд өргөн хүрээнд түгээж, хөтөлбөрийн сурталчилгааны чанарыг сайжруулах.

Зөвлөмж:

- ✓ Ерөнхий суурийн либерал арт хөтөлбөр, нийгмийн ажлын хөтөлбөрийн харилцан хамаарал, уялдаа холбоог хангах, хөтөлбөрт элсэх оюутны хяналтын тоог нэмэгдүүлэх, үүнтэй холбоотой багшлах хүний нөөцийг бэлтгэх.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрт элсэн орсон хоёрдугаар түвшнээс эхлээд төгсөх хүртэлх хугацаанд суралцагчдыг тэнхимтэй холбох, анги удирдсан багшийг томилдог.
- Сайн дурын ажиллагаа, эрдэм шинжилгээ, судалгаа, олон нийт, хүмүүнлэгийн ажилд идэвхтэй оролцуулж, жил бүр Эрэл шийдэл эрэдм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг.
- Суралцагчдад зөвлөн туслах үйлчилгээг хүргэхээр зөвлөх багш буюу анги удирдсан багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нар ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Хөтөлбөрийн суралцагчид, багш нар хоорондын харилцан ойлголцол, хүндлэл, хандлага эерэг бөгөөд багш нарын арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр суралцагчид олон улсын, үндэсний уралдаан тэмцээнд идэвхтэй оролцож, амжилт гаргаснаар хөтөлбөрийн манлайллыг бий болгож байна.

Анхаарах асуудал:

- ✓ Суралцагчдад түвшин бүрт тохирсон зөвлөн туслах үйлчилгээг ижил жигд байдлаар хүргэх,
- ✓ Сургуулийн эмч, сэтгэл зүйчийн ажлын байрны чиг үүргийг хөтөлбөрийн суралцагчдад танилцуулах ажлыг зохион байгуулж, үйлчилгээний шинэ загвар, зааврыг бий болгох

Зөвлөмж:

- ✓ Суралцагчдаас санал авч, түүнийг тусгасан хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн ажлыг дэмжиж, сайн дурын ажлыг идэвхтэй хэрэгжүүлдэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, дадлага хичээл хийх, төгссөний дараа ажлын байранд холбон зуучлах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

- Сургуулийн хэмжээнд нийт 16 оюутан залуусын бүлэг ажилладаг ба Залуу нийгмийн ажилтан клуб 2016 оноос эхлэн тэнхмийн дэргэд үйл ажиллагаа явуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Залуу нийгмийн ажилтан клубийн үйл ажиллагаагаар дамжуулан суралцагчдыг идэвхжүүлэх, олон нийтийн болон, сайн дурын ажилд оролцох боломжийг олгож, залуу багш нар зөвлөн, хамтарч ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- ✓ Нийгмийн ажлыг сурталчлах, төгсөгчдийг ажлын байранд холбон зуучлах ажлуудыг өргөнөөр зохион байгуулах,
- ✓ Суралцагчдыг нийгмийн ажил үйлчилгээний чиглэлээр зохион байгуулж буй аян, чуулган, цахим уралдаан, олон нийтийг хамарсан бусад ажлуудад идэвхтэй оролцуулах, сайн дурын ажлыг хөгжүүлэх үүднээс сургалтаас бусад хөгжлийн асуудлуудад тэдний оролцоог үнэлэн урамшуулал олгодог, тооцдог журам, дүрэм боловсруулж хэрэгжүүлэх

Зөвлөмж:

- ✓ Оюутны гүйцэтгэсэн олон нийтийн болон сайн дурын ажлыг үнэлж, кредит тооцдог олон улсын болон бусад их дээд сургуулиудын туршлагаас судлах, нэвтрүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Баримт нотолгоо:

- Тусгай шаардлага хангасан тохиолдолд хөтөлбөр хоорондын ба гадаад дотоодын их дээд сургуулиас шилжин суралцах боломж нээлттэй байдаг. Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ыг 2019 онд шинэчлэн батлахдаа дотоодын их дээд сургуулиас, хөтөлбөр хооронд шилжин суралцагчдад тавигдах шаардлага, шилжилтийн асуудлаарх цогц асуудлыг нарийвчлан заасан байна.
- ✓ Сүүлийн жилүүдэд суралцагчдаас нийгмийн ажлын хөтөлбөрт шилжин ирж байгаа тоо харьцангуй нэмэгдэж байна.

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрт шилжин ирсэн суралцагчдаас хөтөлбөрийн талаарх санал сэтгэгдлийг сонсож, хөтөлбөрийн танилцуулга үйл ажиллагаанд оролцуулах,
- ✓ Хөтөлбөрөөс шилжин явж байгаа суралцагчдын учир шалтгааныг олж тогтоох, дүн шинжилгээ хийх.

Зөвлөмж:

- ✓ Оюутны шилжилт хөдөлгөөнд багшаас болон хөтөлбөрийн чанараас хамаарах асуудлууд гарсан тохиолдолд авах арга хэмжээний талаар тэнхмийн дотоод журам, дүрэмд тусгах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Баримт нотолгоо:

- Дээд боловсролын бакалаврын зэрэг болзол хангасан суралцагчийн төгсөлтийн салбарын комиссын шийдвэрийг үндэслэн сургуулийн захирлын тушаалаар төгссөн мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, дипломын хавсралт, энгэрийн тэмдэг олгож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ✓ Хөтөлбөр чанарын баталгаажуулалтын алба, Элсэлт бүртгэлийн хэлтсээс оюутны төгсөлтийн үйл явц, төгсөлтийн баримт бичгийн бүрдүүлэлт, баталгаажуулалтад хяналт тавьдаг.
- ✓ Оюутнууд өөрсдийн төгсөлтийн мэдээллийг цахимаар авах үйлчилгээний нөхцлийг бүрдүүлж өгсөн нь мэдээлэл лавлагаа авах асуудлыг шуурхай болгож өгсөн байна.

Анхаарах асуудал:

- ✓ Сүүлийн хоёр жилд төгсөгчдийн диплом хамгаалалт болон төгсөлтийн бичиг баримт гардуулах ажлууд цахим болон шуудан үйлчилгээний хэлбэрт шилжсэнтэй холбоотой оюутнуудын сэтгэл ханамжийн асуулгыг авч, дүгнэлт хийх, цахим үйлчилгээний чанарыг сайжруулах

Зөвлөмж:

- ✓ Төгсөгчдийн дипломын ажил бичих, хамгаалах үеийн цахимаар ажиллах, зөвлөгөө өгөх орчныг бүрдүүлэхэд анхаарах, цахим хамгаалалтын үед гарч буй хүндрэлтэй асуудлуудыг сургуулийн захиргаанд хүсэлт гарган шийдвэрлүүлэх.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Баримт нотолгоо:

- МУИС-ийн дүрэм, МУИС-ийн стратеги төлөвлөгөө (2016-2024), МУИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр (2019-2024), МУИС-д профессор, багш ажиллуулах журам (2019), МУИС-ийн багш, ажилтанд урамшуулалт цалин олгох түр журам (2018), Багш,

ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн журам (2021), Багшийн судалгааны ажлын санхүүжилтийн журам (2018) зэрэг дүрэм журмыг мөрдлөг болгож эрдмийн зэрэг цолтой, сургалт арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.

- “Нийгмийн ажил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавх бүрдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- СНАТ-ийн багшлах бүрэлдхүүний 62,5 хувь докторын зэрэгтэй бөгөөд докторын зэрэгтэй багш нарын 30 хувь профессор, 50 хувь дэд профессорын зэрэглэлд ажиллаж байна.
- Багшлах боловсон хүчнийг Герман, АНУ, Австрали, Бельги, БНХАУ, Япон улсуудын их сургуулиудад нийгмийн ажлын боловсролын чиглэлээр урт болон богино хугацаагаар мэргэшүүлж сургасан байна.
- Багшийг сонгон шалгаруулах шаардлагад МУИС-ийн багшид тавигдах нийтлэг шаардлагыг баримтлахыг зэрэгцээ өндөр хөгжилтэй оронд нийгмийн ажлын магистр, түүнээс дээш зэрэг хамгаалсан байх, гадаад хэлээр академик түвшинд ажиллах, харилцах шалгуурыг тавьж, багшийг шалгаруулан авсан ба МУИС-ийн БХЦСТ-ийн дадлагажигч багшийн сургалтад хамруулсан байна.

Анхаарах асуудал:

- ✓ Багш бүр нийгмийн ажил хөтөлбөрийн зорилго, зорилтууд, мэргэжлийн хөгжлийн стратеги, үзэл баримтлалыг сайтар мэддэг, өөрийн заадаг хичээл, хэрэгжүүлдэг үйл ажиллагаандаа тусгах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Баримт нотолгоо:

- МУИС-ийн стратеги төлөвлөгөө (2016-2024), МУИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр (2019-2024), МУИС-д профессор, багш ажиллуулах журам (2019), МУИС-ийн багш, ажилтанд урамшуулалт цалин олгох түр журам (2018), Багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн журам (2021), Багшийн судалгааны ажлын санхүүжилтийн журам (2018) зэрэг дүрэм журмыг мөрдлөг болгож багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- МУИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын төв байгуулагдаж, эрдэм шинжилгээ, судалгаа, сурган хүмүүжүүлэх, заах арга зүй, хувь хүний хөгжил, мэргэжлийн сургалт, семинаруудыг зохион байгуулсан байна.
- Багшийн судалгаа шинжилгээ, мэргэжил дээшлүүлэх хөгжлийн үйл ажиллагааг санхүүжүүлэн дэмжлэг үзүүлдэг журам хэрэгжиж байна.
- СНАТ-ийн онол арга зүйн семинарыг тогтмол явуулж уламжлал болсон байна.

Анхаарах асуудал:

- ✓ Багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлдэг байх.

- ✓ Нийгмийн ажлын боловсрол, нийгмийн ажлын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх талаар тэнхимийн зүгээс төлөвлөгөөт арга хэмжээ авах
- ✓ Багш нар суралцагчдад зөвлөн туслах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах

Зөвлөмж:

- ✓ Нийгмийн ажил хөтөлбөрийн чанар, үр дүнг сайжруулах зорилгоор хүний нөөцийн төлөвлөлт, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны урт, дунд, богино хугацааны төлөвлөлт хийх
- ✓ Багшийн хөгжлийн үйл ажиллагааны үр дүнг нийгмийн ажил хөтөлбөртэй уялдуулан үнэлж дүгнэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Баримт нотолгоо:

- СНАТ-ийн багш нар сүүлийн 5 жилд олон улсын хэмжээний 8 төсөл, дотоодод 42 төсөлд оролцсон, хэрэгжүүлсэн байна.
- СНАТ-ээс олон улсын эрдэм шинжилгээний хурал 3, дотоодын 5 ЭШХ зохион байгуулсан байна.
- Нийгмийн ажлын багш нараас гадаадад 56 өгүүлэл, дотоодод 80 өгүүлэл хэвлүүлсэн байна.
- Нийгмийн ажлын багш нар гадаад, дотоодод 34 илтгэл хэлэлцүүлж, сурах бичиг, гарын авлага-66 хэвлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- СНАТ-ийн багш нар 79 судалгаа шинжилгээний ажлыг хийж тайлагнасан байна.
- Үндэсний хэмжээний 21 зөвлөн туслах үйлчилгээнд нийгмийн ажлын багш нар ажилласан байна.
- МУИС, СНАТ хамтын ажиллагааны хүрээнд олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран судалгаа, төслийг баг бүрдүүлж гэрээлэн хэрэгжүүлдэг.
- МУИС-ийн дотоод санхүүжилттэй тэтгэлэгт хөтөлбөрт нийгмийн ажлын багш нар хамрагдаж нийт 178 сая төгрөг авсан байна.
- МУИС-аас багшийн судалгааны чадамжийг дээшлүүлэхэд Багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн журам (2021), Багшийн судалгааны ажлын санхүүжилтийн журам (2018) –ын дагуу дэмжлэг үзүүлдэг.

Анхаарах асуудал:

- ✓ Төсөл болон судалгааны үр дүнг нийгмийн ажил хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгах үр нөлөөг нэмэгдүүлэх
- ✓ Нийгмийн ажлын боловсрол, практикийн төслийн үр дүн, эрдэм шинжилгээний бүтээлийн талаар олон нийтэд сурталчлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хэвлэн нийтлэх

Зөвлөмж:

- ✓ Институци талаас СНА Тэнхим чадавхижих, нийгмийн ажил хөтөлбөрийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
- ✓ Олон улсын нийгмийн ажлын боловсрол, судалгаа шинжилгээний төслүүдэд оролцох, нийгмийн ажлын сэтгүүлд хэвлэн нийтлэх
- ✓ Нийгмийн ажлын боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоог нэмэгдүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Баримт нотолгоо:

- МУИС-ийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, МУИС-ийн багш, ажилтанд урамшуулалт цалин олгох түр журам (2018)-ын дагуу багшийн ажлыг үнэлж байна.
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан, сургуулийн систем дэх багшийн бүтээл, ажлын цахим бүртгэл
- Багшийн ажлыг жил бүр, гурван жил тутам гэх мэт хугацаагаар үнэлдэг бөгөөд сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээ гэсэн агуулгаар өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээг хийж, багшийг оноогоор үнэлдэг, урамшуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Багшийн эрдэм шинжилгээний ажлыг цахим бүртгэлд бүртгэн баталгаажуулдаг.
- Багшийн ажлыг үнэлэхэд суралцагч, хамт олон, удирдлага оролцож хөндлөнгийн үнэлгээ хийдэг.
- Багшийн сургалтын үйл явцыг баримтжуулж бичлэг хийдэг.

Анхаарах асуудал:

- ✓ Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тайлагнах
- ✓ Багшийн ажиллах орчныг сайжруулах

Зөвлөмж:

- ✓ Багшийн үнэлгээний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тайлагнах
- ✓ Багш -багшаасаа суралцах үйл ажиллагааг дэмжих, хэрэгжүүлэх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын механизмыг бүрдүүлэн, Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс ажилладаг.
- МУИС нь БСШУЯ, АХБ-ны дэмжлэгээр “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд “Сургалтын чанарын удирдлага, менежментийн төсөл”-ийг хэрэгжүүлж АСИИ-ны хөтөлбөрт тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, стандарт, БМИҮЗ-ийн шалгуур үзүүлэлтийн дагуу МУИС-ийн чанарын менежментийн тогтолцоонд үнэлгээ хийсэн байна.
- МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөө
- МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны журам (2016)
- МУИС-ийн сургалтын журам (2016)
- Нийгмийн ажлын дээд боловсролын стандарт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Давуу тал:**

- МУИС-ийн ХЧБХ-ээс хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийдэг, хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, чанарын баталгаажуулалтын талаар судалгаа хийдэг, хөтөлбөрийн сайжруулалтын талаар заавар чиглэл өгдөг.
- МУИС-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороо, ерөнхий суурь хөтөлбөрийн хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, тэнхимийн хөтөлбөрийн хороо, салбар дундын хөтөлбөрийн хороо шат шатанд хөтөлбөрийн чанар, үнэлгээний чиглэлээр ажилладаг.
- СНАТ-ийн Хөтөлбөрийн хороо байнгын ажиллагаатай.
- МУИС-ийн Сургалтын журам, хөтөлбөрийн журмыг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдсан.

Анхаарах асуудал:

- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж дотооддоо чанарыг хангах, баталгаажуулах

Зөвлөмж:

- ✓ Нийгмийн ажлын боловсрол, сургалтад тавигдах олон улсын стандарт, Монгол улсын Нийгмийн ажлын дээд боловсролын стандартын дагуу хөтөлбөрийн сайжруулалтыг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн цогцоор хийх
- ✓ Хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулийн ижил хөтөлбөрийн эрдэмтэд, олон улсын нийгмийн ажлын сургуулиудын холбоо, нийгмийн ажлын мэргэжлийн холбооны хөтөлбөрийн эксперт шинжээчээр нийгмийн ажил хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийлгэх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийн үр дүнтэй байдал, хэрэгжилтийн талаар судалгаа тандалт хийсэн байна. Ажил олгогчийн судалгаа, төгсөгчдөөс авсан судалгаа зэрэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Нийгмийн ажил мэргэжлээр төгсөгчдийн цогц чадамжийг нийт зургаан цогц чадамжийн хүрээнд тодорхойлж хөтөлбөрөө хэрэгжүүлж байна.
- Суралцагчдын болон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг МУИС-аас жил тутам авдаг. 2021 онд СНАТ-ээс “Нийгмийн ажил мэргэжлээр төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа”-г авсан байна.
- Төгсөгчдийн мөшгих судалгааг 2019 онд хийсэн. Нийгмийн ажил мэргэжлээр төгсөгчдийн 59,8 хувь нь мэргэжлийн салбарт ажиллаж байна. Төгсөгчдийн 31,8 хувь нь мэргэжлийн бус ажил хөдөлмөр эрхэлж байгаа нь судалгаагаар гарсан байна.

Анхаарах асуудал:

- ✓ Төгсөгчдийн судалгааг тогтмолжуулах, судалгааны үр дүнг хөтөлбөрийн чанар, үр дүнг сайжруулахад тусгах

Зөвлөмж:

- ✓ Нийгмийн ажил хөтөлбөрийг боловсронгуй болгох талаар ажил олгогчид, төгсөгчдийн саналыг тогтмол авч, үүний мөрөөр арга хэмжээ авах, үр дүнг гаргах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Баримт нотолгоо:

- Нийгмийн ажил хөтөлбөрийн шинэчлэл хийхдээ олон улсын болон дотоодын их дээд сургуулийн хөтөлбөрүүдийн бенчмарк хийсэн. Үүнд: АНУ-ын Вашингтоны их сургууль, Иллинойсийн их сургууль, Техасын их сургууль, Питсбургийн их сургуулийн хөтөлбөрүүд, түүнчлэн МУБИС, ШУТИС, АШУҮИС, ОУУБИС-ийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан шинжилгээ.
- 2018 онд бакалавр, магистр, докторын түвшний сургалтын хөтөлбөрийн уялдааг тодорхойлсон.
- Магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан
- Төгсөгчдийн судалгааны тайлан
- Ажил олгогчдын судалгааны тайлан
- МУИС-ийн “Нийгмийн ажил” хөтөлбөр нь Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байна. Энэ нь оролцогч талуудын төлөөлөл болох ажил олгогч, төгсөгчдийн санал болон сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Давуу тал:**

- МУИС-ийн СНАТ-ийн багш нар, төгсөгчид, суралцагчдын судалгааны ажлын мэдлэг чадварыг ажил олгогчид, хамтран ажилладаг олон улсын болон үндэсний байгууллагууд, төрийн ба төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд өндрөөр үнэлж байна.
- МУИС-ийн нийгмийн ажлын хөтөлбөр судалгаанд суурилсан хөтөлбөр гэдгээр оролцогч талуудад хүлээн зөвшөөрөгдсөн байна.
- БНХАУ-ын Өвөр Монголоос зургаан суралцагч суралцаж байгаа нь хөтөлбөрийн давуу талыг харуулж байна.

- Нийгмийн ажлын багш нартай гэрээлэн тогтмол хамтран ажилладаг олон улсын болон үндэсний хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагууд байна.
- Олон улсын нийгмийн ажилтны өдрийг мэргэжлийн олон нийтийг хамруулан жил тутам тэмдэглэж ОУНАХ-ны нийгмийн ажлын олон улсын өдрийн уриалгыг орчуулан нийтэд түгээн нөлөөллийн ажил хийдэг нь сайшаалтай.

Анхаарах асуудал:

- ✓ Нийгмийн ажлын мэргэжлийг сурталчлан олон нийтэд таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийгмийн ажлын хөтөлбөр, хэрэгжүүлсэн төсөл, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг мэдээлэх
- ✓ СНАТ институцийн хувьд бэхжих, нийгмийн ажлын боловсрол, практикийг хөгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг стратеги төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

Зөвлөмж:

- ✓ Гадаадын их дээд сургуулийн ижил хөтөлбөрийн эрдэмтэд, олон улсын нийгмийн ажлын сургуулиудын холбоо, нийгмийн ажлын мэргэжлийн холбооны хөтөлбөрийн эксперт шинжээчээр нийгмийн ажил хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийлгэх
- ✓ Гадаад, дотоодын нийгмийн ажлын мэргэжлийн холбоод, нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3	-	-	
2	Сургалтын үйл ажиллагаа	2	1	-	2.3 Суралцагчийн үнэлгээ
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3	-	-	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1	-	4.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа
5	Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа	3	-	-	
6	Багшийн үйл ажиллагаа	4	-	-	
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3	-	-	
Нэгдсэн үнэлгээ		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн “Нийгмийн ажил” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль
Хөтөлбөрийн нэр	Нийгмийн ажил
Хөтөлбөрийн индекс	D092301
Зөвлөмж	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийхдээ ямар шалгуурыг баримтлах, давуу болон сул талаа тодорхойлж, шинэчлэлийг хийХ. ➤ Хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилгод судалгаа хийх, ажил олгогч, төгсөгч нараас санал авах, хэлэлцүүлэх ➤ Мэргэжлийн холбоод, ажил олгогч болон бусад оролцогч талуудын санал, зөвлөгөөг хөтөлбөр шинэчлэхдээ тусгах ➤ 2020 оны Дэлхийн нийгмийн ажлын боловсрол, сургалтын стандартын шаардлагатай нийцүүлж хөтөлбөрийг хөгжүүлэх хэрэгцээ байна.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Батлагдсан сургалтын төлөвлөгөөний оюутанд санал болгох хувилбараар Оюутны цагийн ачаалалд дүн шинжилгээ хийж, тооцох ➤ Дадлага хийсэн оюутнууд болон байгууллагын тоо, дадлага удирдагч, түүнд ногдох цагт дүн шинжилгээ хийж ажиллах ➤ Хичээлийн агуулгын давхардал байгаа эсэхийг нэгж хичээлийн хөтөлбөр тус бүрийн хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэх үедээ нарийвчлан авч үзэх ➤ CDIO загвараар хөтөлбөрийн онцлогтой (нийгэм, хүмүүнлэгийн) нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцох ➤ Хөтөлбөрийн хичээлийн үнэлгээний сан бүрдүүлэн ажиллах, үнэлгээний сангийн агуулга хэлбэрийг зохих түвшинд үнэлдэг байх ➤ Хичээл нэг бүрийн үнэлгээнд тогтмол дүн шинжилгээ хийх ➤ Суралцагчийн тасралтгүй хөгжлийн асуудлаар салбар сургуулийн оюутны холбоотой хамтран ажиллах ➤ Хичээл тус бүрийн танилцуулга нь суралцагчийн мэдлэг, чадварын ерөнхий хүрээгээр тодорхойлогдож байгаа эсэхийг нотлох
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> ➤ Суралцагчид цахим орчинд суралцах, хэрэгтэй мэдээллээ авахад тэдний сэтгэл ханамжид нийцсэн технологийн нөхцлийг бүрдүүлэх, интернетийн хурд, хүртээмжийг нэмэгдүүлэх, ➤ Хөтөлбөрийн онцлогт тохирсон, зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцийн хэрэгцээг тодорхойлсон судалгааг жил

	<p>бүр суралцагчдаас авч байх, судалгаанд суурилсан баяжилтыг тогтмол хийх,</p> <ul style="list-style-type: none"> ➤ Нийгмийн ажлын хөтөлбөрийн багш нар мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ, хүртээмжийн талаар болон цахим хичээл, түүний чанарын талаар суралцагчдаас санал асуулга авч, үр дүнд суурилсан төлөвлөгөө гарган ажиллах.
<p>Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамжийг боловсронгуй болгох ➤ Хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлэх ➤ Мэргэжлийн байгууллага, ажил олгогчидтой хөтөлбөрийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд хамтрах, хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажиллах ➤ Шат шатны Хөтөлбөрийн хороодоос хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж гаргах, үүний мөрөөр тэнхим болон багшийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг үнэлэх дүгнэх ➤ Олон улсын /Ази номхон далайн орнуудын/ нийгмийн ажлын сургуулиудын холбоонд СНАТ институцийн хувьд гишүүнчлэлтэй болох, олон улсын нийгмийн ажлын боловсролын хөтөлбөр, төсөлд хамтрах боломжийг судлах ➤ СНАТ нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийгмийн ажлын хөтөлбөрийг олон нийтэд таниулах, нийгмийн ажлын мэргэжлийг сурталчлах таниулахад анхаарах ➤ Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх ➤ Хөтөлбөрийг сайжруулахад чиглэсэн төлөвлөгөө төсөл, төсөв боловсруулж ажиллах ➤ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш, оюутны хөгжилд үзүүлж буй олон талын эх үүсвэрийн мөнгөн бус дэмжлэгийг тооцож, дүн шинжилгээ хийх ➤ Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуурт санхүүгийн асуудлыг оруулах ➤ Гадаадын улс орны сургуулиудын тэргүүн туршлагыг хөтөлбөрийн санхүүжилт бүрдүүлэхэд дутмаг ашигласан, төгсөгчдийн оролцоо, бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх ➤ Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын нийгмийн асуудлыг дэмжих төсвийг нэмэгдүүлэх ➤ Хөтөлбөрөөр суралцагсдад дэмжлэг үзүүлэх санхүүгийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх
<p>Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Ерөнхий суурийн либерал арт хөтөлбөр, нийгмийн ажлын хөтөлбөрийн харилцан хамаарал, уялдаа холбоог хангах, хөтөлбөрт элсэх оюутны хяналтын тоог нэмэгдүүлэх, үүнтэй холбоотой багшлах хүний нөөцийг бэлтгэх, ➤ Суралцагчдаас санал авч, түүнийг тусгасан хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн ажлыг дэмжиж, сайн дурын ажлыг идэвхтэй хэрэгжүүлдэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, дадлага хичээл хийх, төгссөний дараа ажлын байранд холбон зуучлах,

	<ul style="list-style-type: none"> ➤ Оюутны гүйцэтгэсэн олон нийтийн болон сайн дурын ажлыг үнэлж, кредит тооцдог олон улсын болон бусад их дээд сургуулиудын туршлагаас судлах, нэвтрүүлэх, ➤ Оюутны шилжилт хөдөлгөөнд багшаас болон хөтөлбөрийн чанараас хамаарах асуудлууд гарсан тохиолдолд авах арга хэмжээний талаар тэнхмийн дотоод журам, дүрэмд тусгах, ➤ Төгсөгдчийн дипломын ажил бичих, хамгаалах цахим ажиллагааны үеийн ээлтэй орчныг бүрдүүлэхэд анхаарах, цахим хамгаалалтын үед гарч буй хүндрэлтэй асуудлуудыг сургуулийн захиргаанд хүсэлт гарган шийдвэрлүүлэх.
<p>Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Нийгмийн ажил хөтөлбөрийн чанар, үр дүнг сайжруулах зорилгоор хүний нөөцийн төлөвлөлт, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны урт, дунд, богино хугацааны төлөвлөлт хийх ➤ Багшийн хөгжлийн үйл ажиллагааны үр дүнг нийгмийн ажил хөтөлбөртэй уялдуулан үнэлж дүгнэх ➤ Институци талаас СНА Тэнхим чадавхижих, нийгмийн ажил хөтөлбөрийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ➤ Олон улсын нийгмийн ажлын боловсрол, судалгаа шинжилгээний төслүүдэд оролцох, нийгмийн ажлын сэтгүүлд хэвлэн нийтлэх ➤ Нийгмийн ажлын боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоог нэмэгдүүлэх ➤ Багшийн үнэлгээний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тайлагнах ➤ Багш-багшаасаа суралцах үйл ажиллагааг дэмжих, хэрэгжүүлэх
<p>Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Нийгмийн ажлын боловсрол, сургалтад тавигдах олон улсын стандарт, Монгол улсын Нийгмийн ажлын дээд боловсролын стандартын дагуу хөтөлбөрийн сайжруулалтыг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дорвитой хийх ➤ Хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулийн ижил хөтөлбөрийн эрдэмтэд, олон улсын нийгмийн ажлын сургуулиудын холбоо, нийгмийн ажлын мэргэжлийн холбооны хөтөлбөрийн эксперт шинжээчээр нийгмийн ажил хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ➤ Нийгмийн ажил хөтөлбөрийг боловсронгуй болгох талаар ажил олгогчид, төгсөгчдийн саналыг тогтмол авч, үүний мөрөөр арга хэмжээ авах, үр дүнг гаргах ➤ Нийгмийн ажлын мэргэжлийн холбоод, нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх
<p>ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/</p>	
<p>Шаардлага 2.3: Сургалтын үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрөөр суралцагчдын тасралтгүй хөгжлийн асуудалд анхаарсан дэмжлэгийн тогтолцоог хөгжүүлэх, амжилттай суралцсан суралцагч бүрт урамшууллын талаархи мэдээллийг өгөх, хичээл тус бүрийн үнэлгээнд тогтмол дүн шинжилгээ хийх, суралцагчийн хөгжлийн асуудалд нийгмийн

	хамгааллын мэргэжлийн байгууллага, холбоодын оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байна.
Шаардлага 4.1: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийг шинэчлэх, өөрчлөх төлөвлөгөөний төсөв, түүнийг хэрэгжүүлэгч багш нарын нийгмийн асуудал, хөтөлбөрөөр суралцагсад дэмжлэг үзүүлэх санхүүгийн бодлого, төлөвлөлтийг хийх, хөтөлбөрийн орлогоос орох мөнгөн бус орлогын санхүүжилтыг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, эргэн тайлагнах асуудалд анхаарах шаардлагатай байна. ➤ Хөтөлбөрийн шинэчлэл өөрчлөлтийг хэсэгчилсэн байдлаар бус цогц байдлаар батлах

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Н.Нямдорж/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Н.Оюут-Эрдэнэ/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Д.Мөнхчулуун/

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

1. МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхимийн багш, ажилтны жагсаалт

№	Овог нэр	Албан тушаалын зэрэг	Заадаг хичээл	Ажилласан жил	Мейл хаяг	Утас
1	Ч.Тамир	Тэнхимийн эрхлэгч, доктор	1.Нийгмийн бодлого төлөвлөлт 2.Хээрийн дадлага	Улсад-19, МУИС-18	tamir@num.edu.mn	99120687
2	А.Батхишиг	Дэд проф	1.Нийгмийн ажил (ерөнхий суурь) 2.Хувь хүн гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил 3.Хүүхэд хамгаалал 4.Мэргэжих дадлага	Улсад-28, МУИС-5	batkhisig_a@num.edu.mn	99878556
3	Ш.Оюунханд	Проф	1.Нийгмийн ажлын онол арга зүй 2.Нийгмийн ажлын зөвлөгөө засал, нөхөн сэргээх үйл ажиллагаа 3.Жендерт суурилсан хүчирхийлэл	Улсад 30, МУИС-29	oyunkhand@num.edu.mn	99194701
4	Т.Бүрэнжаргал	Проф	1.Нийгмийн ажлын ёс зүй 2.Нийгмийн давхраажил 3.Мэргэжих дадлага 4. Танилцах дадлага	Улсад-26, МУИС-20	burenjargal@num.edu.mn	99092624
5	Г.Түмэннаст	Дэд проф	1.Нийгмийн ажил (ерөнхий суурь) 2. Нийгмийн хамгааллын түүх 3. Нийгмийн хамгааллын хөтөлбөр ба үйлчилгээ 4.Хээрийн дадлага	Улсад-20, МУИС-20	tumennast@num.edu.mn	99020196

6	М.Батбаатар	Дэд проф	1.Чанарын судалгааны аргууд 2.Бүлэгтэй ажиллах нийгмийн ажил 3.Хүүхдийн хувилбарт халамж үйлчилгээ 4.Мэргэжих дадлага	Улсад-22, МУИС-18	mbatbaatar@num.edu.mn	99164191
7	Я.Отгонбаяр	Дэд проф	1.Нийгмийн ажил (ерөнхий суурь) 2.Хорих байгууллага дах нийгмийн ажил 3.Орон гэргүй иргэдтэй ажиллах нийгмийн ажил 4.Нийгмийн ажил ба ядуурлыг бууруулах нь	Улсад-24, МУИС-11	otgonbayar_ya@num.edu.mn	99193141
8	Б.Нандинцэцэг	Дадлагажигч багш	1.Нийгмийн ажил (ерөнхий суурь) 2.Сургуулийн нийгмийн ажил	Улсад-8, МУИС-1	nandintsetseg@num.edu.mn	99832090
9	Д.Оюунцэцэг	Ахлах багш	1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах нийгмийн ажил 2.Нийгмийн ажил ба нийгмийн эрүүл мэнд 3.Академик бичих ур чадвар	Улсад-24, МУИС-24	oyuntsetseg_d@num.edu.mn	99041401
10	Т.Баярцэцэг	Багш	1.Нийгмийн ажил (ерөнхий суурь) 2.Байгууллага олон нийттэй ажиллах нийгмийн ажил 3.Нийгмийн ажлын нөлөөлөл 4.Нийгмийн энтерпрайз 5.Ахмад настантай ажиллах нийгмийн ажил	Улсад-19, МУИС-11	bayartsetseg@num.edu.mn	99141001
11	О.Мөнхбат	Проф	1.Нийгмийн энтерпрайз 2.Академик бичих ур чадвар	Улсад-31, МУИС-29	munkhbat@num.edu.mn	99093659
12	Д. Мөнхтөр	Ахлах багш	1. Социологи 2. Академик бичих ур чадвар	Улсад-35, МУИС-26	munkhtur@num.edu.mn	99793704
13	Ц.Болд	Ахлах багш	1.Тоон судалгааны аргууд 2.Нийгмийн судалгааны мэдээлэл аргууд	Улсад-27, МУИС-26	bold_ts@num.edu.mn	99031971
14	С.Нарантуяа	Дэд проф	1. Социологи	Улсад-27, МУИС-17	narantuya_s@num.edu.mn	99099720
15	П.Цэрэнбазар	Дэд проф	1.Шилжин ирэгсэдтэй ажиллах нийгмийн ажил	Улсад-14, МУИС-7	tserenbazar@num.edu.mn	99996586
16	А.Тэнүүнжаргал	Дадлагажигч багш	1.Нийгмийн асуудлууд	Улсад-1 МУИС-1	tenuunjaragal@num.edu.mn	88988527
17	Т.Лхамсүрэн	Тэнхимийн туслах ажилтан	Сургалтын үйл ажиллагаанд туслах	Улсад-18 МУИС-11	lkhamsuren_t@num.edu.mn	

2. МУИС-ийн удирдлага, захиргаа, санхүү, бусад албан хаагчтай уулзсан жагсаалт

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	Утас	Цахим хаяг
1	Н.Пүрэвцогт	МУИС-ийн ХЧБА-ны дарга	99037654	purevtsogt@num.edu.mn
2	Б.Болд-Эрдэнэ	Нийгмийн ухааны-салбарын захирал	99166501	bolderdene@num.edu.mn
3	Ч.Тамир	СНАТ-ийн эрхлэгч	99120687	tamir@num.edu.mn
4	О.Мөнхбат	НСХ лаборатори захирал	99093659	munkhbat@num.edu.mn
5	Б. Номинчимэг	НУС-ийн санхүүгийн алба	88062642	nominchimegb@num.edu.mn
6	Ч.Мөнхзул	Номын сангийн каталогич	99064401	munkhzul.ch@num.edu.mn
7	Б. Ихтамир	Ахлах номын санч Цахим уншлага	94512382	ikhtamir@num.edu.mn
8	Д.Хишигболд	БХЦСТ ажилтан		khishigbold@num.edu.mn
9	М. Хатанболд	БХЦСТ студийн ажилтан	88010520	khatanzorigt.m@num.edu.mn

3. Цахим уулзалтад оролцсон суралцагчдын жагсаалт

№	Оюутны овог, нэр	Анги	Сонгосон байдал	Утас	Цахим хаяг
1	Ч.Амаржаргал	НА3	Орон нутаг/Дотуур байр	94280664	amarjargalchuluunbaatar7@gmail.com
2	Э.Рэнцэнжүгдэр	НА3	Хот	99897390	Rentsen.enkh@gmail.com
3	М.Мичидмаа	НА3	Хот	88402909	michidmaaaa@gmail.com
4	А.Намуундарь	НА3	Орон нутаг	80511106	namundari.0106@gmail.com
5	Б.Номин	НА3	Орон нутаг	99879345	nominbayarkhuu368@gmail.com
6	Б.Оюун-эрдэнэ	НА3	Хот	99661455	oyuuk.bat@gmail.com
7	Б.Цэрэндолгор	НА3	Хот	94716422	tserendolgorbyambadorj11@gmail.com
8	Э.Сумьяа	НА3	Орон нутаг/Түрээс	91218123	sumiyae18@gmail.com
9	Э.Буд	НА4	Орон нутаг/Дотуур байр	94354166	bud24699@gmail.com
10	Б.Мөнхбат	НА4	Хот	99399501	muugiib44@gmail.com
11	Б.Буянзаяа	НА4	Хот	94332121	zayanaajin@gmail.com
12	Б.Мөнхзул	НА4	Хот	88503181	Zzulaa9982@gmail.com
13	Ч.Дэлгэрмаа	НА4	Хот	86699095	chinbatdelgermaa@gmail.com
14	С.Шинэгэрэл	НА4	Хот	89292268	shinegerel2017@gmail.com
15	Д.Цэндсүрэн	НА4	Орон нутаг	86828696	Tsendsuren.dagvasuren@gmail.com
16	Б.Эрдэнэсүх	НА4	Орон нутаг/Дотуур байр	80858981	suherdene44@gmail.com
17	Н.Дуламжав	НА4	Хот	89094300	duya770@gmail.com
18	С.Буяндэлгэр	НА2	Хот	86192995	buyandelger1019@gmail.com
19	А.Балдорж	НА2	Орон нутаг/Дотуур байр	89516151	altanbaldorj@gmail.com
20	Ц.Мичидмаа	НА2	Орон нутаг	88074677	michidmaa.tserenpil@gmail.com

4. Цахим уулзалтад оролцсон ажил олгогчдын жагсаалт

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	Утас	Цахим хаяг
1	В.Бэрцэцэг	Монголын Урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбооны Тэргүүн	99122858	bereearththerapy@gmail.com
2	Н.Оюунчимэг	ГБХЗХГ-ын Хяналт, шинжилгээний хэлтсийн дарга	80110048	oyunchimegfcy@gmail.com
3	Н.Бурмаа	Асрал ТББ	95952272	Info.asraljampaling@gmail.com
4	У.Өнөрмаа	Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төв, Гүйцэтгэх захирал	91955115	u.unurmaa@gmail.com
5	Г.Жаргалмаа	Ай ар ай эм ХХК, Захирал	99868690	jargalmaa@irim.mn
6	И.Золдэлгэр	Нийслэлийн ГБХЗХГ-ын дэд дарга	91998699	lzd.zoloo@gmail.com
7	Б.Мөнхжаргал	Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн	99168685	mbujgar@gmail.com
8	М.Энхбадрал	Цогц хөгжлийн үндэсний төвийн Захирал	99106041	Enkhbadral.m@gmail.com
9	О.Лхагвасүрэн	Хүүхэд тусламжийн 108 утасны төвийн захирал	80888444	Moriton8088@gmail.com
10	Б.Оюунтогтох	ДЗМОУБ, Төслийн зохицуулагч	95090214	Boyuntogtokh01@gmail.com
11	Ю.Одгэрэл	ДЗМОУБ, Төсөл хариуцсан захирал	99068568	odkodream@gmail.com
12	Б.Чулуундолгор	Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн		chuluundolgor@gmail.com
13	Л.Мөнхбаяр	ХХҮЕГ, ахлах мэргэжилтэн	99062350	MunkhbayarL.moog@gmail.com
14	Д.Зоригтболд	Нийслэлийн халамж, үйлчилгээний газар, төслийн зохицуулагч	99003354	zzorigtbold@gmail.com
15	Б.Оюундарь	Хөөрхөн зүрх ТББ-ын Ерөнхий зохицуулагч	95959688	Oyundari.bayanbaatar@gmail.com
16	С.Хандмаа	АШУҮИС-ийн Багш, хөгжлийн төвийн захирал	99028676	khandmaa@mnums.edu.mn

5. Цахим уулзалтад оролцсон төгсөгчдийн жагсаалт

№	Овог нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Цахим хаяг
1	Б.Ариунбат	2019	БЗД-ийн ЗХТ-ийн нийгмийн ажилтан	95766990	b.ariunbat.ab@gmail.com
2	П.Нинжбадгар	2016	Завхан аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн	88021811	Ninjinpurev@gmail.com
3	О.Нямбаяр	2017	Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн НА	88814045	Deedii0619@gmail.com
4	У.Өнөрмаа	2014	Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төв, Гүйцэтгэх захирал	91955115	u.unurmaa@gmail.com
5	Г.Жаргалмаа	2016	Ай ар ай эм ХХК, Захирал	99868690	jargalmaa@irim.mn
6	Д.Лхагвасүрэн	2015	Архангай аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн	99599414	Lhagvaa0315@gmail.com
7	О.Ууганбаяр	2016	Дархан-Уул аймаг, НА	99644138	Uuganaa.110423@gmail.com
8	М.Энхбадрал	2014	Цогц хөгжлийн үндэсний төвийн Захирал	99106041	Enkhbadral.m@gmail.com
9	О.Лхагвасүрэн	2018	Хүүхэд тусламжийн 108 утасны төвийн захирал	80888444	Moriton8088@gmail.com
10	П.Сарангоо	2020	Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, НА	88139008	Sarangoo.purevdorj@gmail.com
11	Ю.Одгэрэл	2014-	ДЗМОУБ, Төсөл хариуцсан захирал, НА	99068568	odkodream@gmail.com
12	Б.Лхаеийлхам	2016	Булган аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн, НА	88034460	lkhaeiilam@gmail.com
13	Э.Золзаяа	2020	Смарт ахлах сургуулийн НА	88245425	Zolzayaenkhbaatar112@gmail.com
14	Э.Үл-олдох	2020	Нийгмийн ажилтан	90171731	Oldoh1129@yahoo.mn
15	С.Бадамханд	2008	73-р сургуулийн НА	86777716	Badama.so@gmail.com
16	Б.Батпүрэв	2014	Амьдрах ухаан төв	99703991	batpurev@naran.edu.mn
17	Л.Нямбаяр	2017	Чингэлтэй дүүргийн ЗХТ, НА	94505146	nyambayar@happykids.edu.mn

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46а ил/330, Сүхбаатар дүүрэг,
Бага тосгоуу 47, Утас/Факс: (976-11) 32-54-35,
E-mail: saa@num.edu.mn, http://saa.num.edu.mn

Бод. 06.02 № 7/269

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Тус сургуулийн Нийгмийн ухааны салбарын "Нийгмийн ажил" хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн чиглэлээр ажилласан Шинжээчдийн багийн тайлан, санал зөвлөмжтэй танилцлаа. Санал зөвлөмжийг цаашдын ажилд тусган ажиллах болно.

Хамтран ажилласанд талархал илэрхийлье.

ЗАХИРАЛ



Д.ЗАЯАБААТАР

My.Doc.a bich. p.26

334000286

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн
дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/